



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 13

Мандалговь

“Хоршоо хөгжүүлэх сан”-гийн
төсөл сонгон шалгаруулах
тов зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн 35.1.17, Хоршооны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн 42.1.9, Хүнс хөдөө аж ахуйн сайдын 2021 оны А/361 дугаар тушаалын хавсралтын 2.10, 2.11 дэх заалтуудыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь :

1. “Хоршоо хөгжүүлэх сан”-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг 2022 оны 4 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 4 дүгээр сарын 30-ны өдрийг дуусталх хугацаанд сонгон шалгаруулах товыг зарласугай.

2. Товлогдсон хугацааг хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд болон олон нийтийн цахим, мэдээллийн хэрэгслээр мэдээлж ажиллахыг Жижиг дунд үйлдвэр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн (Ш.Бямба)-д үүрэг болгосугай.

3. “Хоршоо хөгжүүлэх сан”-аас 2022 онд олгох зээлийн төсөлд, батлагдсан тэргүүлэх чиглэлийг баримтлан ажиллахыг төсөл сонгон шалгаруулах хорооны дарга (Ц.Лхагвасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.БАТЖАРГАЛ